



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар В/323

Улаанбаатар хот

**Сонгинохайрхан дүүргийн Дотоод
Аудитын алба эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,321,450 /долоон сая гурван зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун тавин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Дотоод Аудитын алба /Ж.Янжмаа/-нд зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 60,000 /жаран мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 6 нэр төрлийн 7,261,450 /долоон сая хоёр зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун тавин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Дотоод Аудитын алба /Ж.Янжмаа/-нд үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000851

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 29 өдрийн
0/333 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: СХД-ийн Дотоод аудитын алба

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХК-ын шийдвэр
Машин , тоног төхөөрөмж											
1	Компьютер /Acer-i3/	7	ш	1	252,450.00	252,450.00	252,450.00	-	хугацаа дууссан	актлах	татах
2	Компьютер /Dell-i3/	7	ш	4	990,000.00	3,960,000.00	3,960,000.00	-	хугацаа дууссан	актлах	татах
3	Компьютер /Dell-i3/	7	ш	1	869,000.00	869,000.00	869,000.00	-	хугацаа дууссан	актлах	татах
4	Notebook /Dell-inspiron-14/	7	ш	1	950,000.00	950,000.00	950,000.00	-	хугацаа дууссан	актлах	татах
5	Notebook /Dell/	7	ш	1	750,000.00	750,000.00	750,000.00	-	хугацаа дууссан	актлах	татах
6	Принтер HP-1132	7	ш	1	480,000.00	480,000.00	480,000.00	-	хугацаа дууссан	актлах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				9		7,261,450.00	7,261,450.00	0	хугацаа дууссан		
Программ хангамж											
1	Архивын онлайн программ	7	ш	1	60,000.00	60,000.00	60,000.00	0.00	хугацаа дууссан	актлах	устгах
Программ хангамжийн дүн				1.00		60,000.00	60,000.00	0.00			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				10.00	-	7,321,450.00	7,321,450.00	-			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө				9.00		7,261,450.00	7,261,450.00	-			
Актлах хөрөнгө				1.00		60,000.00	60,000.00	-			